

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

**Коронавируст халдварт /COVID-19/-ын цар тахлын үед санхүү,
эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан
сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Коронавируст халдварт /COVID-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эдийн засгийг идэвхжүүлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Доор дурдсан чиглэлээр шуурхай арга хэмжээ авч, хэрэгжилтийн явцын талаар сар тутам Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай:

1/эрүүл, найдвартай, ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай, харилцагчид хүртээмжтэй банкны тогтолцоог хөгжүүлж, банкны салбарын реформ хийх;

2/банкны зээлийн хүүг бууруулах, хөнгөлөлт үзүүлэх, зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах;

3/мөнгө хүүлэлтийг хязгаарлах замаар зээлдэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

4/жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор зээлийн батлан даалтын сангийн хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх;

5/банкнаас бусад санхүүгийн салбарыг хөгжүүлэх;

6/эмч, эмнэлгийн ажилтан, төрийн тусгай албан хаагчдад зориулсан ипотекийн зээлийн шинэ бүтээгдэхүүн гаргах хүрээнд түрээслээд өмчлөх хэлбэртэй орон сууцны тусгай хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх, орон сууцны ипотекийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх;

7/гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх;

8/Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, банкны эрх хүлээн авагч нарын хамтарсан ажлын хэсэг байгуулж, татан буугдсан банкны

чанаргүй активыг шуурхай барагдуулах, төлбөрт хураагдсан үл хөдлөх хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулж, эмнэлэг, сургууль, улсын хэрэгцээнд ашиглах;

9/Төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх;

10/ Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх арга хэмжээний хүрээнд банкинд байршуулсан нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг чөлөөлөх.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/, Төсвийн байнгын хороо /Б.Чойжилсүрэн/-нд тус тус даалгасугай.

4.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

**Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой
байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээ**

| Д/д | Чиглэл | Дугаар | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцах байгууллага |
|-----|---|--------|---|----------------------|
| 1 | Эрүүл, найдвартай, ип тод, нээлттэй, олон нийтийн хяналттай, харилцагчид хүртээмжтэй, үр ашигтай банкны тогтолцоог бий болгох банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөрийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтэх хангах | 1.1 | Эрүүл, найдвартай, ип тод, нээлттэй, олон нийтийн хяналттай, харилцагчид хүртээмжтэй, үр ашигтай банкны тогтолцоог бий болгох банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөрийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтэх хангах | Монголбанк |
| | харилцагчид хүртээмжтэй банкны тогтолцоог хөгжүүлж, банкны салбарын реформ хийх | 1.2 | Банкны зохицой удирдлагын тогтолцоог бурдүүлж, хувь эзэмшилж нээлттэй бууруулах, нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх, банкны хяналт шалгалаат, бутцийн өөрчлөлтийн арга хэмжээний эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хуулийн төсөлт боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэл хангах | Монголбанк |
| | | 1.3 | Цахим банкны үйл ажиллагааг өргөжүүлж, төрөлжсөн цахим банкийг бий болгох | Монголбанк |
| 2 | Банкны зээлийн хүүг бууруулах, хүүний хөнгөлөлт үзүүлэх, зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах | 2.1 | Банкнаас олгосон бүх хэрэглээний зээл /хөнгөлөлттэй санхүүжилттэй ипотекийн зээл, хадгаламж барьцаалсан зээлээс бусад/ болон бичил, жижиг, дунд бизнес /анх 500 сая төгрөгөөс дээш дунтэй олгосон зээл болон жилийн 8%-иас доош хүүтэй олгосон төслийн болон хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлээс бусад-/ийн 500 сая хүртэлх төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийн нийт жилийн нэртэсэн хүүний 5 нэгж хувийг төрөөс, 3 нэгж хувийг банкаас гурван сарын хугацаанд тус тус хариуцах | Засгийн газар |
| | | 2.2 | Харилцах дансанд хүү тооцохгүй байх, гадаад запотын хадгаламжийг албан журмын даатгалд хамруулахгүй байх, иргэн, хуулийн этгээд хоорондын гүйлгээг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэдэг байх агуулгаар Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн санал боловсруулж, Улсын Их Хурлаар хэлэлчүүлэх | Монголбанк |

| | | | | |
|---|--|---|--|---|
| 3 | Мөнгө хүүлэлтийг замаар эзэлдэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг бурдуулэх | 3.1 | Мөнгө хүүлэлтийг тодорхойлж, хязгаарлах, санхүүгийн хэрэглэгэч, зээлдэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр хууль тогтоомжийн төслийг боловсронгуй болгох санапл бэлтгэх | Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк |
| 4 | Жижиг, Үйлдвэрлэл, Үйлчилгээ Эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг хамгаалах эрх зүйн орчныг бурдуулэх | 4.1 | Жижиг, дунд Үйлдвэрлэл, Үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагаанд шаардлагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, иргэдийн орлогын тогтвортой эх Уусвэрийг хангах зорилгоор нэг зээлдэгчид гаргах батлан даалтын дээд хязгаарыг бууруулан тогтоох | Засгийн газар |
| 4 | Жижиг, Үйлдвэрлэл, Үйлчилгээ Эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих, зээлийн үйл ажиллагааг дэмжих зээлийн зорилгоор батлан даалтын сангийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сангийн үйл нэмэгдүүлэх, сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх | 4.2 | Зээлийн батлан даалтын дээд хязгаарыг бууруулан тогтоох хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай зохицуулалтын бодлого, журамд өөрчлөлт оруулах | Санхүүгийн зохицуулах хороо |
| 4 | Жижиг, Үйлдвэрлэл, Үйлчилгээ Эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих зээлийн зорилгоор батлан даалтын сангийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сангийн үйл нэмэгдүүлэх, сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх | 4.3 | Эх оронч худалдан авалтыг дэмжих, чанар, стандартын шаардлага хангасан, дотооддоо Үйлдвэрлэсэн барааг төрийн худалдан авалтаар дэмжих Засгийн газрын "Жагсаалт шинэчлэн батлах тухай" 2019 оны 90 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах | Засгийн газар |
| 5 | Банкнаас бусад санхүүгийн салбарыг хөгжүүлэх | 5.1 | "Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх | Санхүүгийн зохицуулах Хороо |
| 6 | Эмч, эмнэлгийн ажилтан, төрийн тусгай албан хаагч, ажилтанд зориулсан ипотекийн зээлийн тусгай бүтээгдэхүүн гаргах хүрээнд түрээслээд өмчлөх хэлбартай орон сууцны тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлэх, түнд шаардлагатай санхүүжилтийн эх Уусвэр болон хүүгийн татаасыг төрөөс хариуцах, барилгын салбарын зээлийн чанар муудахаас сэргийлэх, ажлын байрыг хадгалах зорилгоор Монголбанкаас олгосон санхүүжилтийн үндсэн төлбөрийн эргэн төлөлтийн хэмжээгээр орон сууцны ипотекийн зээлийг үргэлжлүүлэн санхүүжилтийн хэмжээгээр үйл ажиллагаа эрхлэх бүрэн эрхийг Монголбанканд олгох эрх зүйн тур зохицуулалтыг бий болгох хувь | Засгийн газар Монголбанк Санхүүгийн зохицуулах хороо Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | | |
| 6 | Эмч, эмнэлгийн ажилтан, төрийн тусгай албан хаагчад зориулсан ипотекийн зээлийн бүтээгдэхүүн гаргах, орон сууцны ипотекийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх | 6.1 | Эмч, эмнэлгийн ажилтан, төрийн тусгай албан хаагч, ажилтанд зориулсан ипотекийн зээлийн тусгай бүтээгдэхүүн гаргах хүрээнд түрээслээд өмчлөх хэлбартай орон сууцны тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлэх, түнд шаардлагатай санхүүжилтийн эх Уусвэр болон хүүгийн татаасыг төрөөс хариуцах, барилгын салбарын зээлийн чанар муудахаас сэргийлэх, ажлын байрыг хадгалах зорилгоор Монголбанкаас олгосон санхүүжилтийн үндсэн төлбөрийн эргэн төлөлтийн хэмжээгээр орон сууцны ипотекийн зээлийг үргэлжлүүлэн санхүүжилтийн хэмжээгээр үйл ажиллагаа эрхлэх бүрэн эрхийг Монголбанканд олгох эрх зүйн тур зохицуулалтыг бий болгох хувь | Засгийн газар Монголбанк |
| 6 | Зээлийн эргэн төлөлтийн хугацааг сунгасан Засгийн газрын шийдвэртэй хялдаж байгаа орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүнтэй зээлийн хугацааг зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн улдэлдээл хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр дахин гурав хүртэл сараар хойшиштуулнах | 6.2 | Засгийн газар, Монголбанк | |

| | | | | |
|--|--|-----|---|---|
| | | 6.3 | Энэ арга хэмжээний 6.2 дахь заалтад заасан хөтөлбөрт хамрагдах шаардлагатыг хангасан боловч зээлийн төлбөр хойшлуулах хүсэлт гаргаагүй зээлдэгчийн нийт жилийн нэрласэн хүчиний хоёр нэлж хувьтай тэнцэх хэмжээний дэмжлэгийг турван сарын хугацаанд төрөөс хариуцах | Засгийн газар |
| | | 6.4 | Орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн тогтолцоонд өрөөлдөөн бий болгох, Нийслэлийн орон сууцны корпораци /НОСК/ болон бусад холбогдох хуулийн этгээдэд шинээр шаардлагатай тусгай зөвшөөрөл олгох, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх талаар холбогдох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх | Санхүүгийн Зохицуулах Хороо, Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар |
| | | 7 | Гадаад валютын Нөөцийг Нэмэгдүүлэх | <p>7.1 Засгийн газрын "Алт-2" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх.</p> <p>7.2 Алт опборлогч аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй санхүүжилт олгох, түнд шаардлагдах санхүүжилтийн эх үүсвэрийг зээлийн болон бусад хэлцээр гадаад, дотоод зах зээлзээс бурддүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах, хэлцэл хийх, шийдвэр гаргах бүрэн эрхийг Монголбанканд олгох эрх зүйн түр зохицуулалтыг бий болгох хууль тогтоомжийн төслийн санал болговсруулж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах</p> |
| | | 8 | Төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх | <p>8.1 Цахим худалдаа, төрийн үйлчилгээний төрлийг өргөжүүлж эрчимжүүлэх, цахим хичээлийн нэгдсэн порталь бий болгох, COVID-19 цар тахлын мэдээллийн програм хангамж, апликацийн хөржүүлэх, үйлчилгээг цахим хэлбэрээр авсан бол үнэ тарифыг бууруулах, банк хоорондын шимтгэлийг тэглэх</p> <p>8.2 Төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийхэд Засгийн газрын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангаас дэмжлэг үзүүлэх</p> |

| | | | |
|-----|--|--|---------------------------|
| | | | зохицуулах хороо |
| 8.3 | Олон нийтийг төөрөгдүүлсэн худал ташаа мэдээ, мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх, хягаарлах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгч /цахим хуудас, цахим орчин дахь олон нийтийн сүлжээ, аппликацыйн гэх мэт-/тай хамтран ажиллах зохицуулалтын журмыг боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах | Засгийн газар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо | Засгийн газар Харилцаа |
| 9 | Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар банкны эзэмшиж байгаа Унэт цасыг худалдан авч Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн 5.4-д заасан үүргийг хэрэгжүүлэх | Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар Монголбанк | 000 _____ |